

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн хуралдааны 20 дугаар тэмдэглэлд:

“ХХ.8. “Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахаар бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан гэрээлэгч компаниудын талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:

1. Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэр барихтай холбогдуулан газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг хууль тогтоомжид заасны дагуу дэмжиж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүү болон бүх шатны Засаг дарга нарт даалгав.

2. Газрын тосны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт болон бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой үйл ажиллагааг бодлогын удирдамжаар ханган хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэнд тус тус үүрэг болгов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР